



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 74

Чойр

Аялал жуулчлалыг хөгжүүлэх  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 7 дугаар  
тогтоолын 07 дугаар хавсралт



## **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болон хөгжих зорилтыг тавьсан бөгөөд 2016-аас 2020 онд Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын давцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэхээр тодорхойлсон байна.


“Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого 2010-2021”-д Говьсүмбэр аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэхээр тусгасан. Тус бодлогын баримт бичигт аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн бие даасан тэргүүлэх салбарын нэг болгон, аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэх, менежментийг боловсронгуй болгох, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх зорилтыг тавьсан.

Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 324 дүгээр тогтоолоор Монгол улсын “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт тавин, үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлттэй уялдуулан “Аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

**Өнөөгийн байдал:** Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр нь үндэсний Тулгар төрийн өв, Цагаан зээрийн байгалийн өв, Их говийн байгалийн өв газруудад хамаарагддаг, байгаль, соёлын нөөц бүхий газар, нутаг юм.



Мөн манай аймгийн нутагт Ази Европыг дайран өнгөрдөг эртний Цайны замын гол өртөө байрлаж байсан.



2017 оныг Нэгдсэн үндэсний байгууллагаас “Дэлхийн аялал жуулчлал”-ын жил болгон зарлаж байгаа бөгөөд ЮНЕСКО-ийн санаачлагаар дэлхийн нүүдэлчдийн соёлыг хадгалан авч үлдэхэд онцгой анхаарал хандуулан “Торгоны зам” дагуу нүүдэлчдийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, цаашлаад нүүдэлчдийн аялал жуулчлалын төвүүдийг байгуулахаар төлөвлөж байна. Үүнтэй холбогдуулан Монгол, Хятад, Орос 3 улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд “Цайны зам – Нэг зам – Нэг хөгжил” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд Цайны зам дагуу аялал

жуулчлалын төвүүдийг байгуулан хөгжүүлэх, нүүдэлчдийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл тусгагдсан.

Дээрх төслийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цайны замын судалгааны төв болон бусад холбогдох байгууллагуудаас Цайны зам дагуух өртөө хотуудыг тодруулан, зангилаа хотуудыг “Нүүдэлчдийн аялал жуулчлалын төв” болгон хөгжүүлэх зорилтыг тавин судалгааны ажлыг эхлүүлсэн. Судалгаанд Говьсүмбэр аймгийн Чойрын богд уулын тусгай хамгаалалттай газар хамрагдаж байна.

Манай аймаг нь аргаль хонь, идлэг шонхор, цармын бүргэд, чоно, цагаан зээр, тарвага, үнэг, хярс, туулай, халзгай дорго, үен зэрэг ан, амьтадтай. Үүнээс гадна Шивээ-Овоогийн уурхайн шүүрүүлгийн уснаас бий болсон Шивээгийн булгийн нууранд бух сугас загас үржиж байна.

Хэдийгээр манай аймагт аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй боловч “Боржигин” түмний өлгий нутаг, боржигины өв соёл, зан заншлыг агуулсан түүхэн уламжлалаа сэргээн аялал жуулчлалыг хөгжүүлэх гарц нээлттэй байна.

Үүнээс харахад Чойрын Богд уулын улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн Нүүдэлчдийн болон тусгай сонирхлын эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой юм.

2015 онд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан ба 55 нэршил бүхий газрын 306 үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулж, улсын мэдээллийн санд бүртгэсэн. Үүнд Хүннү, Түргийн үеийн дурсгалууд /булш, хиргисүүрүүд/, хадны зураг, бичээсүүд /Зараа толгойн хадны сүг зураг, Цагаан дарь эх, Дагвасүндэл бурхан г.м/, барилга, архитекторын дурсгал /Чойрын хийдийн туурь, Эрээний хийдийн тууриуд, Хүхээ, Уулзварын голын гүүрний үлдэгдэл г.м/, эртний хөшөө дурсгал /Зараагийн зүүн өврийн хүн чулуу, Замын бууцны хөшөө, Орос цэргийн хөшөө зэрэг 10 гаруй хөшөө хамаарагдана./ , палентологийн дурсгалт газрууд /Хүрэн дух – үлэг гүрвэлийн олдворт газар/ хамаарагдсан.

Цаашид эдгээр дурсгалуудыг судлах, судалгаа шинжилгээ явуулах, эд өлгийн зүйлсийг хадгалж, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох хэрэгцээ бий болж байна.

Монгол улсад ирж буй жуулчдын дийлэнх нь нийслэл Улаанбаатар хотоос аялалын гараагаа эхэлдэг. Манай аймгийн хувьд Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон олон улсын галт тэрэгний транзит төмөр зам, Чойр-Замын Үүдийн хатуу хучилттай зам, олон улсын өндөр хурдны шилэн кабель дайран өнгөрдөг бөгөөд

цахилгаан эрчим хүч, нефть хангамжийн салбар, нефтийн агуулахууд байрладаг зэрэг дэд бүтэц, зам харилцааны давуу талтай.

Аймгийн хэмжээнд 7 иргэн, хуулийн этгээд 41.6 га талбайг жуулчны бааз, амралт, сувилалын газрын зориулалтаар эзэмшиж байгаа боловч байгуулагдсан амралт сувиллын газар, жуулчны бааз байхгүй байна. Одоогоор жуулчин хүлээн авахад зочид буудал, зоогийн газрын хүртээмж, чанар олон улсын зэрэглэлд хүрээгүй, мэргэжлийн боловсон хүчин, маркетинг, сурталчилгаа дутмаг байна.

Манай аймгаар Хэнтий-Өмнөговь, Их Нарт-Дорноговь-Хамрын хийдийн аялал жуулчлалын маршрутын дагуу аялагчид дайран өнгөрдөг учир түр буудаллах цэг, жуулчны бааз байгуулах, зочид буудал, зоогийн газрын хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, хамтарсан аяллын бүтээгдэхүүн бий болгох, цаашлаад БНХАУ, ОХУ-аас жуулчин хүлээн авах орчин нөхцлийг бүрдүүлэх нь чухал юм.

Иймд газар зүйн байршил, дэд бүтцийн давуу тал, маршрут, байгалийн болон түүх соёлын өв, нүүдэлчдийн ахуй соёл, зан заншилд тулгуурласан, орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой нь харагдаж байна.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

#### **Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:**

2.1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийн Хөгжлийн цогц бодлого, Аймгийн Байгаль орчны мастер төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 28 дугаар зорилтод үндэслэн төлөвлөж, зохион байгуулах.

2.2. Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, ил тод, хариуцлагатай, ногоон хөгжлийн зарчимд тулгуурласан арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх

2.3. Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоонд тулгуурлан, санал, санаачлагыг дэмжих замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.

**Зорилго:** Аймгийн газар зүйн байршил, дэд бүтцийн давуу талыг ашиглан, Боржигин өв, соёлд тулгуурласан эко аялал жуулчлалыг дэмжиж, аялал жуулчлалын дэд бүтэц, материаллаг баазыг сайжруулан, аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар гадаад, дотоодын жуулчдын урсгалыг тогтмолжуулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

**Зорилт.1.** Байгалийн болон түүх, соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, Чойрын Богд уулын орчимд аялал жуулчлалын төв байгуулан, хөгжүүлэх

**Зорилт.2.** Боржигин өв соёлыг сэргээж, сурталчлан таниулах, эвент бий болгон хөгжүүлэх

**Зорилт.3.** Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны арга хэмжээг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах

**Зорилт.4.** Хүний нөөцийг чадавхижуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

**Хэрэгжүүлэх хугацаа:** Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2016-2020 онд хэрэгжүүлнэ.

### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа**

***Зорилт.1. Байгалийн болон түүх, соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, Чойрын Богд уулын орчимд аялал жуулчлалын төв байгуулан, хөгжүүлэх***

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Аялал жуулчлалын маршрутын дагуу гол үзмэр болох үл хөдлөх дурсгалуудыг сэргээн засварлах, ойр орчмыг тохижуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

2. Зэрлэг амьтдыг ажиглах цэгүүдийг байгуулан, жуулчдын түр зогсоол, амрах цэгүүдийг тохижуулах.

3. Чойрын богд уулынэнергийг тодорхойлуулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчмын орон нутгийн тусгай хамгаалалтын бүсийг түшиглэн нүүдэлчдийн аялал жуулчлалын төв байгуулах ажлыг эхлүүлж, орчин нөхцлийг бүрдүүлэх. Боржигин үүд цогцолбор байгуулах.

4. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн тусгай сонирхлын аялал жуулчлал /явган болон дугуйн аялал, спорт аялал, нүүдэлчдийн, байгалийн болон шашин мөргөлийн аялал г.м/ -ыг хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх

**Зорилт.2. Боржигин өв соёлыг сэргээж, сурталчлан таниулах, эвент бий болгон хөгжүүлэх**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Боржигин уртын дуу, морин хуур, гар урлалын соёлын өвийг тээгчдийг илрүүлэн, өсвөр үе, залуучуудыг сургаж, өвлүүлэх

2. Боржигин өв соёлыг сурталчлах эвент арга хэмжээнүүд, улсын чанартай уралдаан, тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, соёл, урлаг, шашны болон спортын арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг орон нутагтаа уламжлал болгон зохион байгуулах.

***Зорилт.3. Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны арга хэмжээг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах***

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Улс, бүс, олон улсын үзэсгэлэнд оролцож орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах.

2. Аялал жуулчлалын үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчид, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин улс, бүс, олон улсын үзэсгэлэн, уралдаан, тэмцээнд оролцох боломжоор ханган, дэмжлэг үзүүлэх.

3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах аймгийн танилцуулга, гарын авлага, боршур бэлтгэн олон нийтэд хүргэх.

4. Онлайн хэлбэрээр мэдээ, мэдээллийг хүргэх орчин нөхцлийг бүрдүүлэх

***Зорилт.4. Хүний нөөцийг чадавхижуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх***

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилчид, зочид буудал, зоогийн газар, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилчдыг сургахад дэмжлэг үзүүлэх.

2. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамтран ажиллах малчин өрхүүдийг чадавхижуулах, сургах

3. Аяллын хөтөч, тайлбарлагчдыг бэлтгэх, сургах

4. Жуулчны отог, бааз, зочид буудал, зоогийн газар байгуулах хувийн хэвшлийн санал, санаачлагыг дэмжих, үйлчилгээний чанарыг сайжруулах

***Дөрөв. Үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт***

***Зорилт.1. Байгалийн болон түүх, соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, Чойрын Богд уулын орчимд аялал жуулчлалын төв байгуулан, хөгжүүлэх***

Үр нөлөө:

1. Аялал жуулчлалын маршрутын дагуух гол үзмэрүүд, үл хөдлөх дурсгалуудын хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.

2. 2-оос доошгүй зэрлэг амьтдыг ажиглах цэг байгуулан тохижуулсан байна.

3. Нутгийн малчин иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх боломж нээгдсэн байна.

4. Явган болон дугуйн аялал, спорт загасчлал болон бусад тусгай сонирхлын аялал жуулчлал зохион байгуулагдаж хэвшсэн байна.

**Зорилт.2. Боржигин өв соёлыг сэргээж, сурталчлан таниулах, эвент бий болгон хөгжүүлэх**

Үр нөлөө:

1. 300-аас доошгүй хүүхэд залуусыг сургалтанд хамруулан, соёлын өвийг өвлүүлэх, сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулна.

2. Боржигин нэрийн брэнд аяллын бүтээгдэхүүн гаргаж, уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн байна.

**Зорилт.3. Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны арга хэмжээг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах**

Үр нөлөө:

1. Улаанбаатар Тур, ITM зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн болон бусад арга хэмжээнд тогтмол оролцож, орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа тогтмол сурталчилсан байна.

2. Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодыг дэмжиж улсын уралдаан, зөвлөгөөнд оролцож, амжилт үзүүлж эхэлсэн байна.

3. Иргэд, аялагчдыг мэдээ, мэдээллээр хангах орчин бүрдсэн байна.

4. Аялал жуулчлалын үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлж, цахим хэлбэрээр мэдээ мэдээллийг хүргэж хэвшсэн байна.

**Зорилт.4. Хүний нөөцийг чадавхижуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх**

Үр нөлөө:

1. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар сайжирч, албан хаагчдыг мэргэшүүлсэн байна.

2. Сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.

3. Малчин өрхүүд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн байна.

4. Аялал жуулчлалын төвд мэргэжлийн хөтөч, тайлбарлагч ажиллаж эхэлсэн байна.

5. Жуулчны бааз, амралт, сувиллын газрууд байгуулагдаж, тогтмол үйл ажиллагаа явуулж, жуулчдад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.



### Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2015 он	Хүрэх түвшин, он			
			2017	2018	2019	2020
1	Хүлээн авах жуулчдын тоо	88	150	300	400	500
2	Жуулчны отог, бааз, амралтын газрын тоо	0	1	1	2	2
3	Орон нутагтаа зохион байгуулсан арга хэмжээ, эвентийн тоо	0	1	1	2	2
4	Улс, бүс, олон улсын үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн бусад арга хэмжээнд оролцсон байдал,	2	3	3	3	3
	- Оролцсон арга хэмжээний тоо	4	5	6	7	8
	- Оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн тоо	4	6	8	9	10
	- Оролцсон бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо					
5	Орон нутгийн төсвөөс аялал жуулчлалын салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, сая.төг	-	20.0	20.0	30.0	30.0
6	Аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг малчин өрхийн тоо	-	3	3	5	5

(Суурь түвшний тоон үзүүлэлтийг Аймгийн эдийн засаг нийгмийн статистик үзүүлэлт, Аймгийн эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн тайлан, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2015 оны жилийн эцсийн тайлан, мэдээнээс үндэслэн тодорхойлов.)

#### **Тав. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангах бөгөөд шаардлагатай төсвийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тусгана.

5.2. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар уг хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхийг дэмжинэ.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 4 жилийн хугацаанд нийт 196.5 сая төгрөг, жилд дунджаар 49.1 сая төгрөг шаардагдана. /Авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах төсвийг нарийвчлан тусгав./

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,  
үнэлгээний төлөвлөгөө**

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлал, Боловсрол, соёл, урлаг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн газрууд, Сумдын Засаг даргын Тамгын газрууд хамтран зохион байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг Аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

6.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийн, жилийн эцэст үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 74 дугаар  
тогтоолын 02 дугаар хавсралт



**Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
үйл ажиллагааны төлөвлөгөө**

№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Санхүү-жилт сая.төг	Хариуцах байгууллага
<b>Зорилт.1. Байгалийн болон түүх, соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, Чойрын Богд уулын орчимд аялал жуулчлалын төв байгуулан, хөгжүүлэх</b>							
1	Аялал жуулчлалын маршрутын дагуу гол үзмэр болох үл хөдлөх дурсгалуудыг сэргээн засварлах, ойр орчмыг тохижуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Аялал жуулчлалын маршрутын дагуу гол үзмэр, үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэлжүүлэх	2017	Тооллогын ажлыг зохион байгуулсан байна.	100 хувь	0.5	БОАЖГ БСУГ
2		Аймгийн аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2017-2018	Батлуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.	100 хувь	8.0	АЗДТГ БОАЖГ
3		Аялал жуулчлалын маршрутын дагуу гол үзмэрүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг боловсруулж, мэдээллийн сан үүсгэх	2017	Мэдээллийн сангийн бүрдэл	100 хувь	-	БОАЖГ БСУГ
4		Шаардлагатай гол үзмэр, үл хөдлөх дурсгалуудыг тэмдэгжүүлэх, мэдээллийн самбар	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	5.0	СумдынЗДТ Г БОАЖГ БСУГ

		байршуулах					
5		Шаардлагатай гол үзмэр, үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах	2018-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	20.0	СумдынЗДТ Г ГХБХБГ БОАЖГ, БСУГ
6		Шаардлагатай гол үзмэр, үл хөдлөх дурсгалуудын орчин тойрныг тохижуулах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	20.0	СумдынЗДТ Г ГХБХБГ БОАЖГ, БСУГ
7		Зэрлэг амьтдын байршлыг тодорхойлох	2017	Байршил тодорхой болсон байна.	100 хувь	-	СумдынЗДТ Г БОАЖГ
8	Зэрлэг амьтдыг ажиглах цэгүүдийг байгуулан, жуулчдын түр зогсоол, амрах цэгүүдийг тохижуулах.	Зэрлэг амьтдыг ажиглах цэгүүдийг тодорхойлж, зурагжуулах	2017	Зурагжуулсан байна.	100 хувь	-	СумдынЗДТ Г БОАЖГ ГХБХБГ
9		Зэрлэг амьтдыг ажиглах цэгүүдийг тохижуулах, өндөр хүчин чадлын дуран байршуулах	2018-2019	Тохижуулсан цэгийн тоо	2-оос доошгүй	5.0	СумдынЗДТ Г БОАЖГ ГХБХБГ
10	Чойрын богд уулынэнергийг тодорхойлуулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчмын орон нутгийн тусгай хамгаалалтын бүсийг түшиглэн нүүдэлчдийн аялал жуулчлалын төв байгуулах ажлыг эхлүүлж, орчин нөхцлийг бүрдүүлэх. "Боржигин үүд" цогцолбор байгуулах	Зураг, төсөв боловсруулах	2017	Гүйцэтгэл	100 хувь	5.0	АЗДТГ СумдынЗДТ Г
11		Зураг, төсвийн дагуу шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүлэх /Чойрын хийдийн гол дуганыг сэргээх, Чойрын богд уулын орчим, Хүрийн ногоон нуур, Цоорхойн рашаан орчмын тохижилт/	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	80.0	АЗДТГ СумдынЗДТ Г ГХБХБГ БОАЖГ

12		Чойрын богд уулын энергийг тодорхойлуулан сурталчлах	2017-2020	Энергийг тодорхойлуулсан байна.	Аялал жуулчлалын шинэ урсгалыг бий болгосон байна.	-	АЗДТГ СумдынЗДТ Г ГХБХБГ БОАЖГ
13		Малчин өрхийн судалгааг гарган, хамтран ажиллах нөөцийг тогтоох	2017	Гүйцэтгэл	100 хувь	-	СумдынЗДТ Г БОАЖГ
14		Малчдыг сургах, гэрээ байгуулан хамтран ажиллах	2017-2020	Малчин өрхийн тоо	5-аас доошгүй	-	СумдынЗДТ Г БОАЖГ БСУГ ТББ
15		Аялагчдыг авч, үйл ажиллагааг эхлүүлэх	2018-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	-	СумдынЗДТ Г БОАЖГ БСУГ, ТББ
16	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн тусгай сонирхлын аялал жуулчлал /явган болон дугуйн аялал, спорт аялал, нүүдэлчдийн, байгалийн болон шашин мөргөлийн аялал г.м/ - ыг хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх	Тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газруудыг судлан тогтоох	2017	Гүйцэтгэл	100 хувь	-	БОАЖГ СумдынЗДТ Г
17		Аялагчдыг хүлээн авах түр буудаллах цэгүүдийг тохижуулах ажлыг эхлүүлэх	2017-2020	Түр буудаллах цэгийн тоо	4	8.0	БОАЖГ Сумдын ЗДТГ
18		Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн бус байгууллага, хувийн	2017-2020	Шинээр бий болох аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо	2-оос доошгүй	-	БОАЖГ Сумдын ЗДТГ

		хэвшилтэй хамтран ажиллах					
<b>Зорилт.2. Боржигин өв соёлыг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах бүтээгдэхүүн, эвент бий болгон, хөгжүүлэх</b>							
19	Боржигин уртын дуу, морин хуур, гар урлалын соёлын өвийг тээгчдийг илрүүлэн, өсвөр үе, залуучуудыг сургаж, өвлүүлэх	Соёлын өв тээгчдийг илрүүлэх, сургагч багш бэлтгэн, хүүхэд залуучуудад өвлүүлэх	2017	Гүйцэтгэл	100 хувь	2.0	СумдынЗДТ Г БСУГ
20		Боржигин шагайн тойрмыг сэргээн, уралдаан тэмцээн зохион байгуулах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	2.0	СумдынЗДТ Г АЗДТГ БСУГ
21	Боржигин өв соёлыг сурталчлах улсын чанартай уралдаан, тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, соёл, урлаг, шашны болон спортын арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг орон нутагтаа уламжлал болгон зохион байгуулах.	Боржигин хийцийн гар урлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	1.0	СумдынЗДТ Г АЗДТГ БСУГ
22		Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	1.0	СумдынЗДТ Г АЗДТГ БСУГ
23		Боржигин найрын ёс, жаяг, байшин, хувцас, хэрэглэлийг сэргээн сурталчлах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	2.0	СумдынЗДТ Г АЗДТГ БСУГ
<b>Зорилт.3. Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны арга хэмжээг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах</b>							
24	Улс, бүс, олон улсын үзэсгэлэнд оролцож орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах.	Улаанбаатар Тур, IMV, IMB зэрэг олон улсын үзэсгэлэнд оролцож аймаг, орон нутгийн бүтээгдэхүүн,	2017-2020	Жилд оролцох арга хэмжээний тоо	3-аас доошгүй	1.0	СумдынЗДТ Г БОАЖГ ХХААГ ХАУТ

		үйлчилгээг сурталчлах					
25		Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ, ОХУ болон бусад улс оронд зохион байгуулагдах үзэсгэлэнд орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах	2017-2020	Жилд оролцох арга хэмжээний тоо	2-оос доошгүй	-	СумдынЗДТ Г БОАЖГ ХХААГ ХАҮТ
26	Аялал жуулчлалын үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчид, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин улс, бүс, олон улсын үзэсгэлэн, уралдаан, тэмцээнд оролцох боломжоор ханган, дэмжлэг үзүүлэх.	Мэргэжлийн холбоодыг улс, бүс, олон улсын чанартай ур чадварын уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	1.0	АЗДТГ Сумдын ЗДТГ Мэргэжлийн холбоод
27		Улс, бүсийн чанартай үзэсгэлэн худалдаанд орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах	2017-2020	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	-	Сумдын ЗДТГ БОАЖГ ХХААГ ХАҮТ
28	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах	Аймгийн нэгдсэн танилцуулгыг сэтгүүл хэлбэрээр гаргах	2017	Танилцуулгын тоо	2000 ширхэг	10.0	АЗДТГ Сумдын ЗДТГ
29	Аймгийн танилцуулга, гарын авлага, боршур бэлтгэн олон нийтэд хүргэх.	Аялал жуулчлалын худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний танилцуулга гаргах	2017 2019	Танилцуулгын тоо	2000 ширхэг	5.0	АЗДТГ Сумдын ЗДТГ БОАЖГ

30		Орон нутгийг сурталчилсан тэмдэг, календар, зургийн цомог зэргийг гаргах	2018	Танилцуулгын тоо	2000-аас доошгүй	5.0	АЗДТГ Сумдын ЗДТГ, БОАЖГ
30	Онлайн хэлбэрээр мэдээ, мэдээллийг хүргэх орчин нөхцлийг бүрдүүлэх	Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх	2017	Мэдээллийн сангийн бүрдэл	100 хувь	-	БОАЖГ СумдынЗДТГ
31		Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн танилцуулгыг цахим хуудас, онлайн хэлбэрээр түгээх	2017	Гүйцэтгэл	100 хувь	-	БОАЖГ СумдынЗДТГ
<b>Зорилт.4. Хүний нөөцийг чадавхижуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх</b>							
32	Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилчид, зочид буудал, зоогийн газар, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилчдыг сургахад дэмжлэг үзүүлэх.	Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтран сургалт зохион байгуулах	2017-2020	Жилд зохион байгуулах сургалтын тоо	2	1.0	СумдынЗДТГ БОАЖГ ТББ
33		Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд ажилтан, албан хаагчдыг хамруулж, чадавхижуулах	2017-2020	Хамруулах ажилчдын тоо	Жил бүр 10-аас доошгүй	-	Хувийн хэвшил
34	Аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамтран ажиллах малчин өрхүүдийг чадавхижуулах, сургах	Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтран сургалт зохион байгуулах	2017-2020	Хамрагдах малчин өрхийн тоо Жилд зохион байгуулах сургалтын тоо	10-аас доошгүй 3	1.0	СумдынЗДТГ БОАЖГ БСУГ



35	Аялалын тайлбарлагчдыг сургах	хөтөч, бэлтгэх,	Музей, ТББ-уудын оролцоотой хөтөч, тайлбарлагч бэлтгэх	2017-2020	Бэлтгэх хөтөч, тайлбарлаг- чийн тоо	2	1.0	БОАЖГ БСУГ Музей
36	Жуулчны отог, бааз, зочид буудал, зоогийн газар байгуулах хувийн хэвшлийн санал, санаачлагыг дэмжих, үйлчилгээний чанарыг сайжруулах		Жуулчны отог, бааз, зочид буудал, зоогийн газар байгуулахыг газрын бодлогоор дэмжих	2017-2020	Байгуулаг- дах жуулчны бааз, амралт, сувиллын газрын тоо	2-оос доошгүй	-	ГХБХБГ Сумдын ЗДТГ
37			Жуулчин хүлээн авах чанарын шаардлагыг хангуулж, тохирлын гэрчилгээтэй болгох	2017-2020	Тохирлын гэрчилгээтэй болсон зочид буудал, зоогийн газрын тоо	10-аас доошгүй	-	Аймаг, сумдын ЗДТГ
38			Хаягжилт, хоолны цэс, зэргийг шаардлагад нийцүүлэн шинэчлүүлэх	2017-2018	Гүйцэтгэл	100 хувь	-	Аймаг, сумдын ЗДТГ ГХБХБГ
39			Аялал жуулчлалын зориулалтаар олгогдсон газруудын ашиглалтыг сайжруулж, үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	2017-2018	Байгуулаг- дах жуулчны бааз, амралт, сувиллын газрын тоо	2-оос доошгүй	-	ГХБХБГ Сумдын ЗДТГ
<b>Нийт дүн</b>							<b>196.5</b>	